



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 375

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, сэргээн засварлах боломжгүй болсон ашиглалтын шаардлага хангахгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй, 17 нэрийн нийт 5,282,953.00 (таван сая хоёр зуун наян хоёр мянга есөн зуун тавин гурван) төгрөгийн балансын үнэ, 4,539,407.61 (дөрвөн сая таван зуун гучин есөн мянга дөрвөн зуун долоон төгрөг жаран нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Авлигатай тэмцэх газрын тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар 3.Баасаннямд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132007732

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн
37.6... дугаар тогтоолын хавсралт

Авлигатай тэмцэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
актлаж данснаас хасах хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	Хуриятлагдсан эзэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Сандал дугуйтай	2009-05-19	1	134,750.00	134,750.00	134,750.00	0.00
2	Сандал никель хөлтэй	2007-08-01	1	229,000.00	229,000.00	229,000.00	0.00
3	Сандал төмөр хөлтэй	2007-08-01	1	89,000.00	89,000.00	89,000.00	0.00
4	Хурлын сандал	2012-01-01	1	262,500.00	262,500.00	262,500.00	0.00
5	Сейф	2010-05-28	1	334,000.00	334,000.00	334,000.00	0.00
6	Өлгүүр	2013-01-01	1	199,000.00	199,000.00	199,000.00	0.00
7	Хувцасны шүүгээ	2007-08-01	1	405,000.00	405,000.00	405,000.00	0.00
8	Сандал	2013-01-21	1	119,900.00	119,900.00	102,914.22	16,985.78
9	Сандал хар арьсан	2012-12-28	1	120,000.00	120,000.00	103,923.81	16,076.19
10	Сандал дарга	2013-01-21	1	229,900.00	229,900.00	197,330.49	32,569.51
11	Сандал хүлээлтийн	2013-01-31	1	288,500.00	288,500.00	250,033.33	38,466.67
12	Сандал хурлын	2014-12-25	1	106,603.00	106,603.00	71,068.66	35,534.34
13	Кресло жижиг шар	2012-09-12	1	200,000.00	200,000.00	178,333.16	21,666.84
14	Хувцасны төмөр шкаф	2014-11-19	2	220,000.00	440,000.00	297,000.08	142,999.92
15	Сейф том 2 ш	2013-12-24	1	308,000.00	308,000.00	236,133.33	71,866.67
16	Шкаф	2013-01-21	1	1,416,800.00	1,416,800.00	1,216,087.01	200,712.99
17	Ширээ /бичгийн мөлхөө/	2016-12-28	1	400,000.00	400,000.00	233,333.52	166,666.48
	Нийт дүн		18		5,282,953.00 /таван сая хоёр зуун наян хоёр мянга есөн зуун тавин гурван/	4,539,407.61 /дөрвөн сая таван зуун гучин есөн мянга дөрвөн зуун долоон төгрөг жаран нэгэн мөнгө/	743,545.39 /долоон зуун дөчин гурван мянга таван зуун дөчин таван төгрөг гучин есөн мөнгө/